



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/10/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дорноговь аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Энхцэцэг

Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.05.20 № 16/353

танай _____ -ны № _____ -т

САЙХАНДУЛААН СУМЫН
ЗАСАГ ДАРГА С.НАРАНБАЯР
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сайхандулаан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхандулаан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР _____ Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/мянган төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	484,405.83	794,927.78
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,063,478.57	3,310,233.64
	Нийт хөрөнгийн дүн	3,547,884.40	4,105,161.42
	Нийт өр төлбөрийн дүн	10,364.11	11,271.75
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,537,520.29	4,093,889.67
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,547,884.40	4,105,161.42
Үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,477,837.36	2,633,028.39
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,278,938.16	2,047,602.34
	Үйл ажиллагааны үр дүн	198,899.21	585,426.05
	Үйл ажиллагааны бус үр дүн	73,832.03	29,056.67
	Үйл ажиллагааны нийт үр дүн	125,067.17	556,369.38
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,671,057.05	3,537,520.29
	Тайлант оны үр дүн		556,369.38
	Эцсийн үлдэгдэл	1,671,057.05	4,093,889.67
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,201,261.73	2,120,565.81
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,842,362.46	1,471,685.63
	Үйл ажиллагааны ЦМГ	358,899.27	648,880.18
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(268,635.20)	(330,902.03)
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	90,264.06	317,978.15
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	50,651.51	140,915.57
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	140,915.57	458,893.72
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		1,694,302.84
	Урсгал зардал		1,400,786.41
	Хөрөнгийн зардал		293,516.43
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		2,017,866.61
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		497,979.65
	Улсын төсвөөс санхүүжих		1,367,172.21
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		141,609.42
	НДС-ийн төсвөөс санхүүжих		11,105.32

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайхандулаан сумын Засаг даргын “Хамтдаа хөгжье” үйл ажиллагааны хөтөлбөрийн эрхэм зорилго нь сумын эдийн засаг, нийгмийн өсөлтийг нэмэгдүүлэх, хүндрэлийг даван туулах, төсөв санхүүг оновчтой зохион байгуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэдийг соён гэгээрүүлэх, боловсрол, мэдлэг чадварыг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эрүүл орчинд ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хөгжүүлэн байгаль орчныг хамгаалах, төрийн албаны шуурхай хариуцлагатай байдлыг хангаж төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа өргөжүүлж ажиллана” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хүний хөгжлийн бодлого
- Эдийн засгийн бодлого
- Засаглалын бодлого
- Ногоон хөгжлийн бодлого

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дөрөв. Аудитын гол асуудал

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 147 мэдээллийг заасан хугацаанд байршуулсан байна.

Сумын Засаг даргын баталсан хөрөнгө зарцуулах нийт 377.5 сая төгрөгийн 34 захирамжаас 49.5 сая төгрөгийн 8 захирамжийг шилэн дансны цахим системд байршуулаагүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын ЗДТГ тайлант хугацаанд дансанд Морьтон-Эрдэнэ ХХК-иас хандивын орлого хүлээн авч нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд төвлөрүүлэн зарцуулсан байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 “*Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 байгууллагын ахмадын сан, 3 тусгай сангийн, нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, байгууллага, 2 сан түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан ИТХ, ЭМТөв, ЕБС-ийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, ЗДТГ-ын тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 510.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 493.3 сая төгрөгийн 14 алдааг аудитын явцад залруулж, 8.0 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7.9 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх тухай 7 зөвлөмжийг хүргүүллээ.

Сайхандулаан сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 4.1 сая төгрөгийн 1 алдаа илрүүлж аудитын явцад залруулж, 3.3 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн. Үүнд:

7.1. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд Цэцэрлэгийн бараа материалыг 4.1 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн байна.

7.2. Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага:

Хөрөнгө зарцуулах нийт 377.5 сая төгрөгийн 34 захирамжаас 49.5 сая төгрөгийн 8 захирамжийг шилэн дансны цахим системд байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т *“Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.4.8 *“Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ”* гэсэн заалттай нийцэхгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

7.3. Зөвлөмж

7.3.1. Тус сумын Нөхөн сэргээлтийн санд тайлант хугацаанд менежментийн төлөвлөгөө батлуулаагүй нэр бүхий компаниудаас 3,2 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө байршуулсан байхад байгаль орчны мэргэжилтэн барьцаа хөрөнгө байршуулсан талаар мэдээ судалгаа гаргаж санхүүгийн албатай тооцоо хийгээгүй, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгөөс сумын Засаг даргын 2021 оны А/147 захирамжаар мод тарьсан иргэнд 0.1 сая төгрөгийн урамшуулал олгосон зөрчилд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан *“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 4.1 “Сум, дүүргийн Төрийн сангийн тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын жилийн тайланг тухайн сум, дүүргийн төрийн сангийн төлөөлөгч жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, 12 дугаар сарын 20-ны дотор Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”, 5.5 “БОХ, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг энэхүү журамд зааснаас бусад зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно”* гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

7.3.2. Сумын ИТХ-аар үйл ажиллагааны орлогын болон галт зэвсгийн албан татварыг нэмэгдүүлж, ХХСОАТ-ыг бууруулан баталсан байх боловч ХХСОАТ-ын гүйцэтгэл 18.1 сая төгрөг буюу анх баталснаас 64.8 хувиар давж биелэн орлогыг бодитой бус төлөвлөсөн зөрчилд Төсвийн тухай хуулийн 27.1.2-т *“Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх”* гэсэн заалтыг хэрэгжүүлэн, төсвийн орлогыг өмнөх жилийн гүйцэтгэл болон бодит тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөх, батлах” тухай зөвлөмж хүргүүлээ.

8.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж		Акт		Нийт зөрчлийн дүн		Дүгнэлт
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	ИТХ	1	0.2			3	0			4	0.2	Зөрчилгүй
2	ЗДТГ	2	33.5	2	5.8	3	1.5	2	3.8	9	44.6	Хязгаарлалттай
3	ЭМТөв	2	60.1							2	60.1	Зөрчилгүй
4	ЕБС	3	0.6							3	0.6	Зөрчилгүй
5	Цэцэрлэг					1	0			1	0	Түүвэр
6	Соёлын төв									0	0	Түүвэр
7	СХС	6	398.9							6	398.9	Түүвэр
8	ОНХС			1	2.1			1	4.2	2	6.3	Түүвэр
9	НСС					1	3.3			1	3.3	Зөрчилгүй
10	СНТ	1	4.1			1	0			2	4.1	
Нийт дүн		15	497.4	3	7.9	9	4.8	3	8	30	518.1	

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.